



"ДАРХАН ТӨМӨРЛӨГИЙН ҮЙЛДВЭР"  
ТӨХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ  
П.ЭРДЭНЭЦОГТ ТАНАА

МОНГОЛ УЛСЫН  
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

210646 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,  
Бага тойруу, Засгийн газрын IV байр,  
Утас: 26-04-37, Факс: 32-32-66

2014.03.31 № 1/20 УАТ-САТ/2014/40/СПГА/ТХК

Зөрчил арилгуулах тухай

Төрийн Аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлд тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд "Дархан төмөрлөгийн үйлдвэр" ТӨХК-ийн 2013 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд аудит хийхэд дараах зөрчил илэрлээ. Үүнд:

- "Хенлонг" ХХК-тай 2006 оны 11 дүгээр сарын 22-ны өдөр байгуулсан №ХХ-2006-41 тоот гэрээний дагуу 17,312.4 мянган тонн ган бөмбөлөгийн бэлдэц нийлүүлж, төлбөрт нийт 6578.5 мянган ам доллар авахаас 6099.9 мянган ам долларыг авч, үлдэгдэл 478.7 мянган ам долларыг тус компанийн нэр дээр бүртгэх естий байтал тус авлагыг "Эрдэнэт үйлдвэр" ХХК-иас авах авлагын дунд оруулан тооцож Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1.4 "Эд хөрөнгийн тооллого хийх, үр дүнэ шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тогтоосон хугацаанд тооцоо нийлж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах" заалтыг зөрчсөн,
- "Дархан Шар Бүрд" ХХК-тай 483.4 сая төгрөгийн авлагыг тооцоо нийлж баталгаажуулсан боловч данс бүртгэлд 805.1 сая төгрөгөөр буюу 321.7 сая төгрөгөөр илүү тусгаж Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1 "санхүүгийн тайлан нь үнэн, зөв, баримт материал, бодит тоо, мэдээнд үндэслэх" заалтыг зөрчсөн.
- "Дархан Шар Бүрд" ХХК-иас авлагадаа суутган тооцсон 521.7 сая төгрөгийн орон сууцийг компанийн хөрөнгөнд хүлээн зөвшөөрч орлогод аваагүй зэрэг нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 "Аж ахуйн нэгж, байгууллага нь хөрөнгө, өр төлбөрөө нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэлж дансанд тусгана." заалтыг зөрчсөн зөрчлийд илэрлээ.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12 "аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх...", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2009 оны 47 дугаар тушаалаар батлагдсан "Төлбөрийн акт тавих, албан шаардлага өгөхөд баримтлах журам"-ын 3.1.1 "...алдаа зөрчлийг арилгуулахаар төрийн аудитын байгууллага холбогдох

албан тушаалтанд албан шаардлага өгнө” гэсэн заалтуудыг үндэслэн  
**ШААРДАХ НЬ:**

Дээрх зөрчлүүдийг арилган, албан шаардлагын биелэлтийг 2014 оны 6 дугаар сарын 30-ны дотор Үндэсний Аудитын газарт албан ёсоор хариу ирүүлэхийг “Дархан төмөрлөгийн үйлдвэр” ТӨХК-ийн гүйцэтгэх захирал П.Эрдэнэцогт, ерөнхий нягтлан бодогч Д.Даваадорж нарт хариуцуулав.

